



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 23 өдөр

Дугаар

А/847

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Замын хөдөлгөөний соёл 2020 урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний зардалд зориулан 1 500 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх төсөл арга хэмжээнд зарцуулагдах 1 500 000 төгрөг /нэг сая таван зуун мянган/ -ийг аймгийн 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын жагсаалтын 5.21 дэх заалтад тусгагдсан “Тайван амгалан Ховдчууд” хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ